



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ**

# **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

**Улаанбаатар хот  
2024 он**

# ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

## Агуулга

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон байдал

Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал

Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төрлөөр боловсруулсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>1</sup>-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж

<sup>1</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төслийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

**“Практикт хэрэгжих боломж”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд туссан дараах зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгахар сонгож авав. Үүнд:

- Хуулийн төсөлд /7 дугаар зүйл/ хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт /аж ахуйн нэгж, байгууллагад/-д ачаалал, бэрхшээл учруулах эсэх, хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардал гарах эсэхийг үнэлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл /9 дүгээр зүйл/ бүрдүүлэхтэй холбогдож шаардлагатай тохируулгаар хангах, явуулын болон багшийн туслахын үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг үнэлэх;
- Онцгой байдлын үед авах арга хэмжээ /31 дүгээр зүйл/ хэрэгжих боломжийг үнэлэх;
- Хуулийн төсөл дэх төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийн хуваарилах, зарцуулалтад хяналт тавих гэсэн зохицуулалт хэрэгжих боломжтой эсэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах талаарх зохицуулалтыг үнэлэх.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтууд нь хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг үнэлэхийг зорив.

**“Зардал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөсөн, шимтгэлийн хувь хэмжээг бууруулсан, нийгмийн даатгалын хуримтлалын сан байгуулах зэрэг зохицуулалттай холбогдон гарах тооцоолол хийх мөн “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

## **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ**

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хамгаалах талаар баримтлах зарчим, иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагын эрх, үүрэг, оролцоо, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор дараах гол зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Хуульд заасан зарим ойлгомжгүй нэр томъёоны найруулгыг залруулж, нэр томъёоны хүрээг өргөжүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчмыг тодорхойлох;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангаж, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох;

3. Нийгмийн халамжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүргэж байгаа зарим үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болгох;

4. Онцгой байдлын үе, ялангуяа, зуд, үер зэрэг байгалийн гамшиг, цар тахал зэрэг нийтийг хамарсан аюулын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй тусламж, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;

5. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийн хуваарилах замаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, салбар, яамд, нутгийн захиргааны оролцоог хангах;

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийг бэлтгэх, салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

***Зорилт 1. Хуульд заасан зарим ойлгомжгүй нэр томъёоны найруулгыг залруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр шинэ ойлголтыг тайлбарлах талаар:***

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт нийт 11 нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д тусгагдаагүй шинээр нэмэгдсэн зарим нэр томъёонд үнэлгээ хийхээр сонголоо. Үүнд:

4.1.3. “туслах бүтээгдэхүүн” гэж хувь хүний үйлдэл, бие даасан байдлыг сайжруулах, эсхүл хэвийн хэмжээнд нь хүргэх зориулалттай хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл, тоног төхөөрөмж, харилцаа холбоо, мэдээлэл технологийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн бүтээгдэхүүнийг;

4.1.4. “шаардлагатай тохируулга” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.5. “туслах технологи” гэж туслах бүтээгдэхүүн, шаардлагатай тохируулга, түүний үйлчилгээг хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг;

4.1.11. "Ажлын байрны дадлагажуулагч" гэж ажлын байран дээр аж ахуйн нэгж, байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг холбон ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, энэ чиглэлийн арга зүйг эзэмшсэн хүнийг".

**Зорилт 2.** *Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангаж, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар*

БШУЯ-ны 2023-2024 оны хичээлийн жилийн мэдээгээр дээд боловсролын байгууллагад суралцагчдын 0,33 хувь, үүнээс бакалаврын түвшинд суралцагчдын 0,36, магистрын 0,09, докторын түвшний 0,2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Нийт хүн амын 11 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд энэ үзүүлэлттэй харьцуулахад тэдний сурах эрх хангагдахгүй байгаа учир боловсролын бүх түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүн суралцахыг дэмжих шаардлагатай

Иймд одоогийн хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны боловсрол эзэмшихэд шаардлагатай тохируулга, дэмжлэгийн талаарх зохицуулалтыг хуулиар зохицуулах шаардлагатай байгаа тул хуулийн төсөлд хэрхэн тусгасанд үнэлгээ хийхээр сонгосон болно.

**Зорилт 3.** *Нийгмийн халамжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүргэж байгаа зарим үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болгох талаар*

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1-26.1.16-д хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн төрлийг заасан хэдий ч 26.1.1-26.1.5-д заасан арга хэмжээг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр хуульчилсан байна. харин үлдсэн арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой болгоогүйгээс хэрэгжүүлэх боломжгүй болж, иргэдээс энэ байнга өргөдөл, гомдол ирж байна. Иймд хуулийн төслийн 22.1-д заасан арга хэмжээг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр зохицуулсан бөгөөд хэрэгжих боломжийг үнэлэх болно.

**Зорилт 4.** *Онцгой байдлын үе, ялангуяа, зуд, үер зэрэг байгалийн гамшиг, цар тахал зэрэг нийтийг хамарсан аюулын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй тусламж, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх талаар*

Байгалийн гамшиг, цар тахлын тохиолдоход хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэрэг хүн амын эмзэг хэсэгт түүний үр нөлөө нь хамгийн их хүндээр тусдаг. Түүнчлэн иргэдийг аюул осол, гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй байгууллагад ажиллагчид буюу онцгой байдлын аврагч, сайн дурынхан, нийт иргэдийн хувьд ч тэдэнд хэрхэн туслалцаа үзүүлэх талаар ойлголт мэдлэг тааруу байдаг. Иймд энэ хуульд онцгой байдлын үед авах арга хэмжээний асуудлыг нарийвчлан зохицуулсан бөгөөд энэ зохицуулалтад үнэлгээ хийхээр сонгож авлаа.

**Зорилт 5.** *Төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийн хуваарилах замаар*

*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, салбар, яамд, нутгийн захиргааны оролцоог хангах талаар*

Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал нь Засгийн газрын тухай хуулиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг хэдий ч бүхий л салбарын бодлого, үйл ажиллагаатай зайлшгүй уялдуулах шаардлагатай билээ. Ийм ч учраас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хорооны бүрэлдэхүүнд бүх яамны Төрийн нарийн бичгийн дарга нар орж ажиллдагаас гадна яамд болон зарим агентлагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл, нийслэл, аймаг, дүүрэгт салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

Ийм бүтэц байгуулагдсан хэдий ч хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө байхгүйгээс хэрэгжилт хангалтгүй байсан. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхээр төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад шаардлагатай зардлыг тусгах зохицуулалтыг тусгаж, үнэлгээ хийхээр сонголоо.

**Зорилт 6.** *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийг бэлтгэх, салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах талаар*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг хүний нөөц цалин хөлс болон нийгмийн хамгааллын дэмжлэг хангалтгүй байгаагаас үүдэн тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаагаас үүдэн хүний нөөцийн дутагдалд ороод байна. Жишээлбэл, 2019 онд байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төвд нийт 143 орон тоогоор ажиллахаас 46 орон тоо одоогоор хоосон байна. Энэ салбарт ажиллагчдын хувьд цалин бага, ажлын ачаалал их, сэтгэл санааны хувьд хүнд байдгаас ажлаас халшрах шалтгаанаар тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байна. Иймд салбарын хүний нөөцийг бэхжүүлэхтэй холбоотой асуудлыг тусган хэрэгжих боломжийг үнэлэхээр сонгож авлаа.

## **ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, Сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох

2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 7.1.1, 7.1.2 18.3	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх. Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Зардал	“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоо хийх	а/ Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөсөн, шимтгэлийн хувь хэмжээг бууруулсан, хуримтлалын сан байгуулах зэрэг зохицуулалттай холбогдон гарах тооцоолол хийх б/ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлын тооцоо хийх /аргачлалын дагуу тусад нь хийх/
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдааг холбох

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

**1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

**Зорилт 1** Хуульд заасан зарим ойлгомжгүй нэр томъёоны найруулгыг залруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр шинэ ойлголтыг тайлбарлах зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр давхардал, хийдэгдэл, хууль хоорондын зөрчлийг арилгах, цаг үеийн нөхцөл байдлын улмаас нэмэх шаардлагатай болон бусад орхигдсон зохицуулалтыг тодорхойлоход хуульд хэрэглэсэн зарим нэр томъёог нэмж тусгах нь зүйтэй гэж үзсэн. Мөн зарим нэр томъёог хассан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн “Хуулийн нэр томъёо” зүйлээс 6 тодорхойлолтыг хасаж, 5 тодорхойлолтыг нэмж, 2 нэр томъёоны найруулгад өөрчлөлт оруулсан байна. Хуулийн төсөлд нийт 11 нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан байна.

Хуулийн төсөлд, “хөгжлийн бэрхшээлтэй хүн”, “олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ”, “дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” зэрэг нэр

томъёог найруулгыг залруулж илүү ойлгомжтой тодорхойлсноос гадна шинээр “туслах бүтээгдэхүүн”, “шаардлагатай тохируулга”, “туслах технологи”, “ажлын байрны дадлагажуулагч” “гэсэн тодорхойлолтуудыг нэмж тодорхойлсон байна. Харин “тохирох бүтээгдэхүүн”, “боломжит дээд хэмжээ”, “урьдчилан сэргийлэх”, “туслах хэрэгсэл”, “асаргаа сувилгааны хэрэгсэл”, “ариун цэвэр, эрүүл ахуйн маериал” гэсэн нэр томъёог хассан байна

Шинээр нэмэгдсэн нэр томъёонууд нь өргөн утгатай бөгөөд нийт хуулийн хэмжээнд хэд дахин хэрэглэгдэж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.4, 30.6, 30.7-д заасан шаардлагыг хангасан байна. Тухайлбал:

4.1.3.“туслах бүтээгдэхүүн” гэж хувь хүний үйлдэл, бие даасан байдлыг сайжруулах, эсхүл хэвийн хэмжээнд нь хүргэх зориулалттай хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл, тоног төхөөрөмж, харилцаа холбоо, мэдээлэл технологийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн бүтээгдэхүүнийг;

4.1.4.“шаардлагатай тохируулга” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.5.“туслах технологи” гэж туслах бүтээгдэхүүн, шаардлагатай тохируулга, түүний үйлчилгээг хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг;

4.1.11.“Ажлын байрны дадлагажуулагч” гэж ажлын байран дээр аж ахуйн нэгж, байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг холбон ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, энэ чиглэлийн арга зүйг эзэмшсэн хүнийг”

***Зорилт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангаж, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар талаар үнэлгээ хийсэн нь:***

БШУЯ-ны 2023-2024 оны хичээлийн жилийн мэдээгээр дээд боловсролын байгууллагад суралцагчдын 0,33 хувь, үүнээс бакалаврын түвшинд суралцагчдын 0,36, магистрын 0,09, докторын түвшний 0,2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Нийт хүн амын 11 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд энэ үзүүлэлттэй харьцуулахад тэдний сурах эрх хангагдахгүй байгаа учир боловсролын бүх түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүн суралцахыг дэмжих шаардлагатай байна.

Хуулийн төслийн “9 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх”, “10 дугаар зүйл. Сурч боловсрох нөхцөл”-ийн 10.1.1-д “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд зааснаас гадна тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн дэмжигч, явуулын болон багшийн туслахын дэмжлэгтэйгээр боловсрол эзэмшүүлж, цаашид дэвшин суралцахад туслалцаа үзүүлэх;” 10.1.2-т “элсэлтийн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн шаардлагатай тохируулгаар хангаж, хүртээмжтэй орчин, нөхцөлд зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт цаг олгох.” 10.2-т “Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын



байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ” гэж зохицуулсан. .

Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид шаардлагатай тохируулгаар хангагдаж, зарим дэмжлэг авах, мэргэжлийн боловсролын болон их, дээд сургуульд элсэн суралцах, сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх боломжийг болгож байгаа юм.

***Зорилт 3. Нийгмийн халамжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүргэж байгаа зарим үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой болгох талаар үнэлгээ хийсэн нь:***

Нийгмийн даатгалд хамрагдаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, дэмжлэг үзүүлэх харилцааг Нийгмийн халамжийн тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар зохицуулж байна. Тухайлбал, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу 16 насанд хүрсэн одой хүн, хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгон авч байна. Бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа иргэнд сар бүр асаргааны тэтгэмж, байнгын асаргаатай 16-гаас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүнд улирал бүр, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд сар бүр мөнгөн тусламж олгож байна. Түүнчлэн ганц бие, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээ болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд протез, ортопед хийлгэх, амралт, рашаан сувилалд сувилуулах болон орон сууцны хөлс, түлшний үнийн хөнгөлөлт эдлүүлэх зэрэг хөнгөлөлт үйлчилгээ үзүүлж байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1-26.1.16-д хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн төрлийг заасан хэдий ч 26.1.1-26.1.5-д заасан арга хэмжээг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр хуульчилсан байна. Харин үлдсэн арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой болгоогүйгээс хэрэгжүүлэх боломжгүй болж, иргэдээс энэ байнга өргөдөл, гомдол ирж байна.

Хуулийн төслийн 22.1-д “Энэ хуулийн 4.1.1-д заасан хүнд Нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлтийг үзүүлнэ” гээд 22.1.1-22.1.14-т тусламж, хөнгөлөлтийн төрлийг заасан. Мөн 22.2-т “Энэ зүйлийн 22.1-д заасан хөнгөлөлт, тусламжийн жагсаалт, жишиг үнэ, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална”, “22.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино”, “22.4.Энэ зүйлийн 22.3-т заасан харилцааг зохицуулах журмыг Засгийн газар баталж, шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, Нийслэлийн жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ” гэж өмнө зохицуулагдаагүй байсан хийдэгдлийг арилгах арга хэмжээг авсан.

Түүнчлэн асаргаа, сувилгааны хэрэгсэл /бүх төрлийн живх, катетр гэх мэт/, ариун цэвэр-эрүүл ахуйн материал /цооролт, холголтын үед цэвэрлэх спирт, хөвөн, бинт, ариун наалт гэх мэт/ зүйлс нь эмчлэх, сэргээн засан үйл ажиллагаанд өдөр тутам ашиглагддаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд эдгээр зүйлсийг байнга хэрэглэдэг хэдий ч Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөд хамрагддаггүйгээс тэдэнд маш их хүндрэл гарч байна. Иймд энэ асуудлыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд дараах байдлаар нэмэлт оруулан тусгалаа.

22.6.Энэ хуулийн 4.1.1-д заасан хүнд Эрүүл мэндийн даатгалын сангаас доор дурдсан үйлчилгээг санхүүжүүлнэ:

22.6.1. магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан болон сувилалд сувилуулахад:

22.6.1.а. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зардлыг бүрэн;

22.6.1.б. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг асран халамжилж буй нэг иргэнийн зардлын 50 хувь;

22.6.1.в. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний зардлын 50 хувь.

22.6.2. асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материал;

22.6.3. холголт, цооролтын үеийн эмчилгээний зардал.

Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн “24.6.7. удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэг, хөнгөвчлөх болон холголт, цооролтын үеийн эмчилгээ, эм, асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын зардал.” өөрчлөн найруулахаар төслийг боловсрууллаа.

***Зорилт 4. Онцгой байдлын үе, ялангуяа, зуд, үер зэрэг байгалийн гамшиг, цар тахал зэрэг нийтийг хамарсан аюулын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй тусламж, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх талаар тусгасан***

Байгалийн гамшиг, цар тахлын тохиолдоход хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэрэг хүн амын эмзэг хэсэгт түүний үр нөлөө нь хамгийн их хүндээр тусдаг. Түүнчлэн иргэдийг аюул осол, гамшгаас хамгаалах чиг үүрэгтэй байгууллагад ажиллагчид буюу онцгой байдлын аврагч, сайн дурынхан, нийт иргэдийн хувьд ч тэдэнд хэрхэн туслалцаа үзүүлэх талаар ойлголт мэдлэг тааруу байдаг. Иймд энэ хуульд онцгой байдлын үед авах арга хэмжээний асуудлыг нарийвчлан зохицуулсан бөгөөд энэ зохицуулалтад үнэлгээ хийхээр сонгож авлаа.

Хуулийн төсөлд

31.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал, цар тахал зэрэг онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүний амь нас, эрүүл мэндийг нь хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

31.1.1. онцгой байдлын мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн хүртээмжтэйгээр хүргэх;

31.1.2.хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

31.1.3.энэ хуулийн 28.2.1, 28.2.5-д заасан дэмжих үйлчилгээг байгалийн гамшиг, цар тахлын үеийн хөл хорио, нийтийг хамарсан үймээн самуун, бослого тэмцэл, ажил хаялт, бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдээс үл хамааран бүх цаг үе, нөхцөл байдалд тасалдуулахгүй авах боломжоор хангах.

31.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх онцгой байдлын үеийн арга хэмжээтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна. гэж тусгалаа.

Түүнчлэн Гамшгаас хамгаалах тухай хуульд

“13.6.Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан сургалтын агуулгад хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах, аврах агуулгыг заавал тусгана”

“25.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө батлан хэрэгжилтэд хяналт тавина.”

“30.5.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хувийн туслахын болон дохионы хэлмэрч зэрэг дэмжих үйлчилгээгээр хангагдах эрхээ эдлэх боломжийг заавал бүрдүүлнэ.” Гэж тусгалаа.

Ийнхүү эдгээр зохицуулалтууд нь зорилгоо хангаж чадахуйцаар тусгагдсан байна гэж үнэлж байна.

***Зорилт 5.Төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийн хуваарилах замаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, салбар, яамд, нутгийн захиргааны оролцоог хангах талаар тусгасан байдалд үнэлгээ хийсэн байдал:***

Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал нь Засгийн газрын тухай хуулиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг хэдий ч бүхий л салбарын бодлого, үйл ажиллагаатай зайлшгүй уялдуулах шаардлагатай билээ. Ийм ч учраас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хорооны бүрэлдэхүүнд бүх яамны Төрийн нарийн бичгийн дарга нар орж ажиллдагаас гадна яамд болон зарим агентлагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл, нийслэл, аймаг, дүүрэгт салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

Ийм бүтэц байгуулагдсан хэдий ч хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө байхгүйгээс хэрэгжилт хангалтгүй байсан. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхээр төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад шаардлагатай зардлыг тусгах зохицуулалтыг тусгаж, үнэлгээ хийхээр сонголоо.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсанаар УИХ, Засгийн газрын тогтоолоор батлагдсан төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, стратеги зэрэг 80 гаруй бичиг баримтыг Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон. Энэ хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр мөн хүчингүй болсон бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан бага хэмжээний хөрөнгө хуваарилдаг байсан боловч энэ санхүүжилт бүрэн зогссон.

Одоогийн байдлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр дэмжих сангаас олгодог санхүүжилтээс өөр энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулдаг санхүүжилт байхгүй байна.

Иймд хуулийн төсөлд улс, нутгийн төсвийн зардлын ангилалд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг оруулж, бүх яамд, бүх шатны Засаг дарга нарын багцад жил бүр хөрөнгө хуваарилдаг болох эрх зүйн зохицуулалтыг дараах байдлаар тусгалаа:

35.1.Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр, улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг эрхэд суурилсан хандлагад нийцүүлэн тусгаж хэрэгжүүлэх;

35.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

35.2. Засгийн газрын гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.2.1.санхүүгийн асуудал хариуцсан засгийн газрын гишүүн салбарын онцлогт нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн төсвийн эдийн засгийн ангиллыг Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр үүсгэн батлах;

35.2.2.Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан Стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг заавал тусган хэрэгжүүлэх;

35.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусган зарцуулах, олон нийтэд тайлагнах.

Эдгээр зохицуулалт нь зорилгоо бүрэн илэрхийлсэн гэж үнэллээ.

**Зорилт 6.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийг бэлтгэх, салбарын ажилтны нийгмийн баталгааг хангах талаар үнэлгээ хийхэд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг хүний нөөц цалин хөлс болон нийгмийн хамгааллын дэмжлэг хангалтгүй байгаагаас үүдэн тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаагаас үүдэн хүний нөөцийн дутагдалд ороод байна. Жишээлбэл, 2019 онд байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төвд нийт 143 орон тоогоор ажиллахаас 46 орон тоо одоогоор хоосон байна. Энэ салбарт ажиллагчдын хувьд цалин бага, ажлын ачаалал их, сэтгэл санааны хувьд хүнд байдгаас ажлаас халшрах шалтгаанаар тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байна.

Иймд хуулийн төслийн 41 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгаа” гэсэн зүйлийг шинээр нэмж, дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

41.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтан Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

41.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтанд ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн урамшуулал олгох;

41.1.2. орон байр барих эсхүл худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламжид хуульд заасны дагуу хамрагдах;

41.1.3. тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах;

41.1.4. хуульд заасан бусад баталгаа

41.2. Энэ хуулийн 42.1-т заасан нийгмийн баталгааны хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, шаардлагатай хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн жилийн төсөвт тусгана.

Иймд шаардлагатай хөрөнгийг жил тусган, хуульд заасан дэмжлэгийг үзүүлснээр зохицуулалтыг хийх бүрэн боломжтой гэж үнэлэв.

**2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

*1/Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалт зохион байгуулах боломжийн талаарх зохицуулалтад хийсэн үнэлгээ*

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтын хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Эдүгээ ... сургагч бэлтгэх эрхтэй сургагч багш, ... сургалт явуулах эрх бүхий сургагч багштай болсон байна. 2018 онд ... хүнийг сургалтад хамруулж байсан бол 2023 онд энэ үзүүлэлт ... болж өссөн байна.

Гэвч аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ойлгох, хөдөлмөрийн харилцаанд ороход нь дэмжлэг үзүүлэх, тохируулгатай орчин бүрдүүлж, хамт олны нэг хэсэг болгон төлөвшүүлж, хөгжүүлж чадахгүй байгаагаас тогтвор суурьшилтай ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр хөдөлмөр эрхлэх боломж бүрдэхгүй байна.

Иймд хуулийн төсөлд:

7.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, түүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагыг хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамруулах,

7.1.2. иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах тухай зохицуулалтыг тусгалаа.

Энэ сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энэ чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотой зохион байгуулах боломжтой тул зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой гэж үнэллээ.

*2/Энэ хуулийн 32.2.4-т заасан салбар зөвлөл нь 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээнд нийцсэн туслах бүтээгдэхүүн олгох шийдвэр гаргах зохицуулалтын хэрэгжих боломжийн үнэлгээ*

Хуулийн төслийн 32 дугаар зүйлд

32.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ тогтооно:

32.2.1.0-18 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зөвлөл;

32.2.2.18 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрүүл мэндийн магадлалын зөвлөл;

32.2.3.үйлдлийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих шийдвэрийг эмнэлэг хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн магадлалын зөвлөл.” гэж тусгасан.

Энэ зохицуулалт одоогийн мөрдөгдөж байгаа хуульд ч туссан бөгөөд Эмнэлэг, хөдөлмөр, магадлах комисс нь насанд хүрэгчдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоодог. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож холбогдох үйлчилгээнд зуучлах шийдвэрийг гаргадаг.

Гэвч одоогийн мөрдөгдөж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан “протез, ортопед, тусгай хэрэгсэл”-ийг хэн олгох зохицуулалт тодорхой бус байсан бөгөөд зөвхөн нарийн мэргэжлийн эмчийн шийдвэрээр олгож ирсэн байна. Иймд энэхүү хуулийн төсөлд заасан “туслах бүтээгдэхүүн” гэж нэрийг оновчтой болгож, олгох шийдвэрийг дээрх зөвлөлүүд гаргахаар хуулийн төслийг боловсрууллаа.

### **3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.1-д зааснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээ хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулж, нийтдээ 11 бүлэг, 44 зүйлтэй, хуулийн төслийн бүтэц, хэлбэр, дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.

29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Зарим анхаарах асуудал байна.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан



#### 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;

Хуулийн төслийн 32.2.2-т “18 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрүүл мэндийн магадлалын зөвлөл”, 32.2.3-т “үйлдлийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих шийдвэрийг эмнэлэг хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж заасан. Олон улсын эрүүл мэнд, үйлдлийн чадварын ангиллыг хэзээнээс ашиглаж эхлэх, хэн аргачлалыг батлах зэрэг нь тодорхойгүй байгааг анхаарах

Хуулийн төслийн 19.2-т “Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тухайн хүний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Ямар байгууллага энэ үйлчилгээг эрхлэх талаарх зохицуулалт тодорхойгүй байгааг анхаарах

#### **4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг хавсаргав.

### **ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

#### **Дүгнэлт**

Хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

#### **Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн.

*Зорилт 1-6-г* хангахад чиглэгдсэн зохицуулалтууд нь зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон байна.

#### **Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр:**

Сонгож авсан зохицуулалтын хувьд дараах дүгнэлтийг хийлээ.

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт тусгана. Мөн Сангийн сайд төсвийн зардлын ангилалд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах санхүүжилтийг хуваарилахаар тусгасан нь төсөв, санхүүгийн хувьд хамгийн оновчтой шийдэл болсон байна.

2.Туслах бүтээгдэхүүн олгох шийдвэрийг нэг болон цөөн эмч гаргадаг байсныг өөрчилж, Эрүүл мэндийн магадлах зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зөвлөл гаргахаар боловсруулсан байна. Энэ нь хамтын шийдвэр гаргаж, тухайн хүнийх нь хэрэгцээ шаардлагад нийцсэн туслах бүтээгдэхүүн авах, нөгөө талаас Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зөв зарцуулахад чиглэсэн зөв зохицуулалт болсон байна.

### **Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийхэд хуулийн төслийг ойлгомжтой болгох чиглэлээр санал ирүүлээгүй байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

### **Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан.

Хуулийн төслийн зарим заалт, зохицуулалтыг нэгтгэх, хариуцлагын асуудлыг нягталж нэг заалт болгох, тодорхой болгоход анхаарах шаардлагатай гэж дүгнэлээ.

### **Зөвлөмж**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлж дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1. Үйлдлийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох асуудлыг хуульд тодорхой болгох;
2. Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг чухам ямар байгууллага энэ үйлчилгээг эрхлэх талаарх зохицуулалт тодорхойгүй байгааг анхаарах.